ТӨВ АЙМАГ ДАХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

**АУДИТЫН КОД: ТӨА-2022/28/НА-СТА-ТШЗ**

**ТӨВ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМАН ДАХ МЭРГЭЖИЛ СУРГАЛТ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Зуунмод 2022 он

Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: “Дундманхайдай Аудит” ХХК

Утас: 11-325262 Цахим хаяг: dum_audit@yahoo.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар авна уу.

Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт ........................................ 3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........................................ 5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ........................................ 5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ........................................ 7
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ........................................ 9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ........................................ 10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ........................................ 12
3. Аудитын тайлан ........................................ 14
3.1 Ерөнхий зүйл ........................................ 14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт ........................................ 14
3.4 Материаллаг байдал ........................................ 15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга ........................................ 15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........................................ 16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг ........................................ 17
3.8 Аудитын гол асуудал ........................................ 17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........................................ 17
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........................................ 17
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........................................ 18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........................................ 18
4. Аудитын илрүүлэлт ........................................ 19
4.1 Залруулсан алдаа ........................................ 19
4.2 Төлбөрийн акт ........................................ 19
4.3 Албан шаардлага ........................................ 19
4.4 Зөвлөмж ........................................ 19

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| МУЕА | Монгол Улсын Ерөнхий аудитор |
| ТБОНӨ | Төрийн болон орон нутгийн өмч |
| НҮБ-ын ХХААБ | Нэгдсэн Үндэсний байгууллагын Хүнс хөдөө аж ахуйн байгууллага |

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

41100 Зуунмод, Төв аймаг
Утас: 70272248. Факс: 70272582, Имэйл: tuv@audit.gov.mn

2022.02.24 № 01/51
танай ________ -ны № ________ -т

ТӨВ АЙМГИЙН ЭРДЭНЭ СУМАН ДАХЬ МЭРГЭЖИЛ СУРГАЛТ, ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТӨВИЙН ЗАХИРАЛ Ш.ОТГОНХҮҮ ТАНАА

**Зөрчилгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Эрдэнэ суман дахь Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Эрдэнэ суман дахь Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.ХИШИГЖАРГАЛ

19020220

D 2022/2022 он/ALBAN BICHIG

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **101,911,579.70** | **53,499,395.74** |
| **33** | **АВЛАГА** | 679,600.00 | 679,600.00 |
| **335** | **Бусад авлага** | 679,600.00 | 679,600.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 679,600.00 | 679,600.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 101,231,979.70 | 52,819,795.74 |
| **351** | **Түүхий эд материал** | 14,930,000.00 | 14,930,000.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 14,930,000.00 | 14,930,000.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 71,701,979.70 | 19,219,795.74 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,145,070.00 | 429,090.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 35,987,981.00 | 9,858,630.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 1,189,150.00 | 00.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 5,056,761.82 | 1,398,680.76 |
| 35450 | Барилгын засварын материал | 8,254,450.00 | 3,331,500.00 |
| 35460 | Хүнсний материал | 5,734,967.58 | 2,488,127.58 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 13,333,599.30 | 1,713,767.40 |
| 35600 | Мал амьтад | 14,600,000.00 | 18,670,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,202,084,970.74** | **1,255,888,779.15** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,202,084,970.74 | 1,255,888,779.15 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,064,627,482.86 | 1,113,058,779.15 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 958,396,923.85 | 958,396,923.85 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -86,026,817.74 | -122,638,795.18 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 13,435,859.83 | 111,235,859.83 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -10,119,571.71 | -11,225,001.15 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 578,030,228.40 | 608,026,428.40 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -424,525,883.44 | -467,363,736.19 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 111,514,080.66 | 119,872,080.66 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -92,301,277.69 | -99,468,921.77 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 830,000.00 | 830,000.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -830,000.00 | -830,000.00 |
| 39217 | Ном | 16,223,940.70 | 16,223,940.70 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 137,457,487.88 | 142,830,000.00 |
| 39301 | Программ хангамж | 15,875,000.00 | 19,733,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -12,103,778.76 | -15,875,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 162,128,000.00 | 162,128,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -28,441,733.36 | -23,156,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,303,996,550.44** | **1,309,388,174.89** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,303,996,550.44** | **1,309,388,174.89** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,303,996,550.44 | 1,309,388,174.89 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 464,952,792.60 | 464,952,792.60 |
| 51101 | Өмч: - төрийн | 464,952,792.60 | 464,952,792.60 |

| | | | |
|---|---|---|---|
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -370,402,781.48 | -365,011,157.03 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -370,402,781.48 | -365,117,048.12 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 105,891.09 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,209,446,539.32 | 1,209,446,539.32 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,303,996,550.44** | **1,309,388,174.89** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,231,633,646.11** | **1,356,486,620.65** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **119,887,646.11** | **209,941,320.65** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 119,887,646.11 | 209,941,320.65 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 119,887,646.11 | 209,941,320.65 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,817,800.00 | 1,920,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 308,980.00 | 1,250,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 117,760,866.11 | 206,771,320.65 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,111,746,000.00** | **1,146,545,300.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,111,596,000.00 | 1,146,545,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,111,596,000.00 | 1,146,545,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 150,000.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 150,000.00 | 00.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,288,755,445.13** | **1,349,080,729.56** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,288,755,445.13** | **1,349,080,729.56** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,136,398,527.91 | 1,223,106,261.62 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 654,341,927.78 | 715,495,794.39 |
| 210101 | Үндсэн цалин | 393,376,901.82 | 499,946,904.67 |
| 210102 | Нэмэгдэл | 177,796,093.96 | 137,619,923.46 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 50,074,975.00 | 21,443,997.51 |
| 210104 | Урамшуулал | 33,093,957.00 | 56,484,968.75 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 98,654,495.00 | 93,549,488.77 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 70,019,166.40 | 65,319,780.66 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,494,965.77 | 7,239,276.20 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,975,811.91 | 5,710,780.93 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,483,396.93 | 1,389,059.21 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,681,153.99 | 13,890,591.77 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 104,197,957.00 | 83,970,795.06 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 35,303,035.00 | 33,899,241.00 |
| 210302 | Түлш, халаалт | 64,291,102.00 | 46,082,274.06 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,603,820.00 | 3,989,280.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 23,079,938.41 | 62,390,515.61 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,868,420.00 | 1,936,300.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,554,908.41 | 2,721,864.50 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,122,700.00 | 6,295,838.21 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,096,800.00 | 2,996,586.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,577,110.00 | 786,134.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 7,860,000.00 | 47,653,792.90 |
| **2105** | **Нормативт зардал** | 22,126,193.50 | 23,614,530.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 611,500.00 | 171,800.00 |
| 210502 | Хоол, хүнс | 21,116,693.50 | 23,442,730.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 398,000.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 23,298,210.00 | 60,121,920.65 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 338,000.00 | 809,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 22,960,210.00 | 59,312,120.65 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 90,000.00 | 72,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 90,000.00 | 72,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,876,400.00 | 70,944,453.28 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,475,000.00 | 64,741,057.35 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 00.00 | 2,500,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 00.00 | 2,231,995.93 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 121,500.00 | 158,400.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 25,000.00 | 57,600.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 495,000.00 | 483,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 759,900.00 | 772,400.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 206,733,406.22 | 112,946,763.86 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 12,181,400.00 | 00.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 20,676,443.00 | 21,452,638.91 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 173,875,563.22 | 91,494,124.95 |
| **212** | **ТАТААС** | 113,545,917.22 | 34,248,567.94 |
| **2121** | **Төрийн өмчит байгууллагад олгох татаас** | 113,545,917.22 | 34,248,567.94 |
| 212101 | Төрийн өмчит байгууллагад олгох татаас | 113,545,917.22 | 34,248,567.94 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 38,811,000.00 | 91,725,900.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 38,811,000.00 | 91,725,900.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 5,912,700.00 | 48,142,900.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 31,078,300.00 | 42,124,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,820,000.00 | 1,458,600.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-57,121,799.02** | **7,405,891.09** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 7,300,000.00 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 00.00 | 7,300,000.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | -7,300,000.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-57,121,799.02** | **105,891.09** |

## 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 464,952,792.60 | 176,329,651.15 | -217,022,596.42 | 00.00 | 424,259,847.33 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **464,952,792.60** | **176,329,651.15** | **-217,022,596.42** | **00.00** | **424,259,847.33** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -125,006,979.85 | 00.00 | -125,006,979.85 |
| C08 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **464,952,792.60** | **1,209,446,539.32** | **-370,402,781.48** | **00.00** | **1,303,996,550.44** |
| D01 | **2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **464,952,792.60** | **1,209,446,539.32** | **-370,402,781.48** | **00.00** | **1,303,996,550.44** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 5,285,733.36 | 00.00 | 5,285,733.36 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **464,952,792.60** | **1,209,446,539.32** | **-365,117,048.12** | **00.00** | **1,309,282,283.80** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 105,891.09 | 00.00 | 105,891.09 |
| D09 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **464,952,792.60** | **1,209,446,539.32** | **-365,011,157.03** | **00.00** | **1,309,388,174.89** |

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,113,872,780.00** | **1,149,715,300.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,126,780.00** | **3,170,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 2,126,780.00 | 3,170,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 2,126,780.00 | 3,170,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,817,800.00 | 1,920,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 308,980.00 | 1,250,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,111,746,000.00** | **1,146,545,300.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,111,596,000.00 | 1,146,545,300.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,111,596,000.00 | 1,146,545,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 150,000.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 150,000.00 | 00.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,101,691,380.00** | **1,149,715,300.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,101,691,380.00** | **1,149,715,300.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **949,334,462.78** | **1,023,740,832.06** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 654,341,927.78 | 715,495,794.39 |
| 210101 | Үндсэн цалин | 392,576,901.82 | 499,946,904.67 |
| 210102 | Нэмэгдэл | 176,584,093.96 | 137,619,923.46 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 29,986,200.00 | 21,443,997.51 |
| 210104 | Урамшуулал | 55,194,732.00 | 56,484,968.75 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 98,654,495.00 | 93,549,488.77 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 70,019,166.40 | 65,319,780.66 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,494,965.77 | 7,239,276.20 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,975,811.91 | 5,710,780.93 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,483,396.93 | 1,389,059.21 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 13,681,153.99 | 13,890,591.77 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 106,392,620.00 | 80,312,714.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 35,303,035.00 | 33,899,241.00 |
| 210302 | Түлш, халаалт | 66,485,765.00 | 42,424,193.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,603,820.00 | 3,989,280.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 16,771,200.00 | 15,980,638.21 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,251,100.00 | 1,855,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,743,000.00 | 2,704,300.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,122,700.00 | 6,303,838.21 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 5,232,000.00 | 3,000,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,422,400.00 | 2,117,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 27,513,620.00 | 21,643,490.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,671,800.00 | 171,800.00 |
| 210502 | Хоол, хүнс | 22,592,220.00 | 19,955,390.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 3,249,600.00 | 1,516,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 17,535,800.00 | 967,800.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,009,800.00 | 807,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 16,526,000.00 | 160,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 90,000.00 | 72,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 90,000.00 | 72,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 3,876,400.00 | 74,781,953.28 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 00.00 | 64,741,057.35 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,475,000.00 | 2,500,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 00.00 | 2,231,995.93 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 121,500.00 | 158,400.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 25,000.00 | 57,600.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 495,000.00 | 4,333,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 759,900.00 | 759,900.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 24,158,400.00 | 20,936,953.41 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 24,158,400.00 | 20,936,953.41 |
| **212** | **ТАТААС** | **113,545,917.22** | **34,248,567.94** |
| **2121** | **Төрийн өмчит байгууллагад олгох татаас** | 113,545,917.22 | 34,248,567.94 |
| 212101 | Төрийн өмчит байгууллагад олгох татаас | 113,545,917.22 | 34,248,567.94 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **38,811,000.00** | **91,725,900.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 38,811,000.00 | 91,725,900.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 5,912,700.00 | 48,142,900.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 31,078,300.00 | 42,124,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,820,000.00 | 1,458,600.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **12,181,400.00** | **00.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **12,181,400.00** | **00.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **12,181,400.00** | **00.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 12,181,400.00 | 00.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 12,181,400.00 | 00.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-12,181,400.00** | **00.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,155,045,300.00 | 1,149,715,300.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,155,045,300.00 | 1,149,715,300.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,063,315,800.00 | 1,023,740,832.06 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 731,570,700.00 | 715,495,794.39 |
| 210101 | Үндсэн цалин | 478,807,500.00 | 499,946,904.67 |
| 210102 | Нэмэгдэл | 160,018,800.00 | 137,619,923.46 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 27,840,000.00 | 21,443,997.51 |
| 210104 | Урамшуулал | 64,904,400.00 | 56,484,968.75 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 98,762,000.00 | 93,549,488.77 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 69,499,200.00 | 65,319,780.66 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,315,700.00 | 7,239,276.20 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 5,852,600.00 | 5,710,780.93 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,463,100.00 | 1,389,059.21 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 14,631,400.00 | 13,890,591.77 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 94,207,400.00 | 80,312,714.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 36,208,600.00 | 33,899,241.00 |
| 210302 | Түлш, халаалт | 54,008,700.00 | 42,424,193.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 3,990,100.00 | 3,989,280.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 15,980,800.00 | 15,980,638.21 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,855,500.00 | 1,855,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,704,300.00 | 2,704,300.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 6,304,000.00 | 6,303,838.21 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,000,000.00 | 3,000,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,117,000.00 | 2,117,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 26,033,600.00 | 21,643,490.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 171,800.00 | 171,800.00 |
| 210502 | Хоол, хүнс | 24,345,500.00 | 19,955,390.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,516,300.00 | 1,516,300.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 967,800.00 | 967,800.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 807,800.00 | 807,800.00 |
| 210604 | Урсгал засвар | 160,000.00 | 160,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 72,000.00 | 72,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 72,000.00 | 72,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 74,784,200.00 | 74,781,953.28 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 64,741,500.00 | 64,741,057.35 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 2,500,000.00 | 2,500,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 2,232,000.00 | 2,231,995.93 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 158,400.00 | 158,400.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 59,400.00 | 57,600.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 4,333,000.00 | 4,333,000.00 |
| 210809 | Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх | 759,900.00 | 759,900.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 20937300.00 | 20936953.41 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 20,937,300.00 | 20,936,953.41 |
| **212** | **ТАТААС** | 00.00 | 34,248,567.94 |
| **2121** | **Төрийн өмчит байгууллагад олгох татаас** | 00.00 | 34,248,567.94 |
| 212101 | Төрийн өмчит байгууллагад олгох татаас | 00.00 | 34,248,567.94 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 91729500.00 | 91725900.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 91,729,500.00 | 91,725,900.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 48,142,900.00 | 48,142,900.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 42,124,400.00 | 42,124,400.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,462,200.00 | 1,458,600.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,155,045,300.00 | 1,149,715,300.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,146,545,300.00 | 1,146,545,300.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,146,545,300.00 | 1,146,545,300.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 8,500,000.00 | 3,170,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 7,000,000.00 | 1,920,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,500,000.00 | 1,250,000.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 01.00 | 01.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 01.00 | 01.00 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 55.00 | 55.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 03.00 | 03.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 33.00 | 33.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 19.00 | 19.00 |

## 3. Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Төв аймгийн Эрдэнэ суман дах Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг шийдвэрлэх, бараа материалын бүртгэлийг сайжруулах, шилэн дансны мэдээллийг үнэн зөв мэдээлж, хуулийн хэрэгжилтийг бүрэн ханган ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Аудитор С.Батжаргал, Э.Батчимэг нар гүйцэтгэж, чанарын хяналтыг “Дундманхайдай Аудит” ХХК-ний Чанарын хяналтын менежер Б.Цэвэлмаа, захирал Ж.Бямбажав нар хэрэгжүүлж, хяналтыг Төв аймаг дах Төрийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Эрдэнэ суман дах Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 21-ний өдрийн 01/07 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төв аймгийн Эрдэнэ суман дах Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төв нь стандартад нийцсэн хөдөө аж ахуйн сургалтын шинэлэг орчныг бүрдүүлж, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, ажил олгогчийн шаардлагад нийцсэн, зөв төлөвшилтэй, чадварлаг ажилтан бэлтгэхийг эрхэм зорилгоо болгон Мэргэжлийн боловсрол олгоход чиглэгдсэн үйл ажиллагаа явуулдаг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны харьяа байгууллага юм.

Төв аймгийн Эрдэнэ суман дах Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ерөнхий боловсролын дунд сургуулийн үйл ажиллагаа
- Мэргэжлийн боловсрол олгоход чиглэгдсэн үйл ажиллагаа

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төв аймгийн Эрдэнэ суман дах Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвийн Захирлын 2021 оны 02 дугаар сарын 03-ны өдрийн А/06 тоот тушаалаар Дотоод хяналт, үнэлгээний багийг 6 хүний бүрэлдэхүүнтэй томилж, 2021 оны ажлын төлөвлөгөөг батлуулан, төлөвлөгөөний хэрэгжилтийг хагас, бүтэн жилээр гаргаж ажилласан байна.

Төв аймгийн Эрдэнэ суман дах Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

**3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Эрдэнэ суман дах Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төв нь 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

**3.4 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2021 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангийн батлагдсан төсөвт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны батлагдсан төсөвт зардал 1,155,045.3 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 17,325.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 12,994.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

**3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга**

Төв аймгийн Эрдэнэ суман дах Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төв нь 2021 оны санхүүгийн үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Мэргэжил боловсрол, сургалтын тухай хууль, ТБОНӨ-ийн тухай хуулиудыг мөрдлөг болгон ажиллаж 2021 оны 01 дүгээр сарын 01-ээс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон санхүүгийн тайлант хугацааны үйл ажиллагаа, санхүүгийн үр дүнг тусган тайлагнасан байна.

Санхүүгийн үйл ажиллагаандаа “Санхүүгийн тооцоолох” ХХК-ний “Payroll”, “Acolous” санхүүгийн программыг ашиглаж байна.

***Төсвийн гүйцэтгэл, орлогын талаар:***

Тус байгууллага нь 2021 онд улсын төсвөөс 1,146,545.3 мянган төгрөгийн санхүүжилтийг 100 хувь авсан. Үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого 8,500.0 мянган төгрөгийн төлөвлөгөөтэй, гүйцэтгэлээр 3,170.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлж, 37.1 хувийн биелэлттэй байна. Нэмэлт санхүүжилтийн дансанд орлого төвлөрөөгүй байна.

***Үндсэн хөрөнгө, бараа материалын талаар:***

Үндсэн хөрөнгө дансанд Жигд хүч ХХК-аас нийгмийн хариуцлагын хүрээнд 5,000.0 мянган төгрөгийн гагнуурын ангийн тоног төхөөрөмж, НҮБ-ын ХХААБ-аас нийт 112,147.8 мянган төгрөгийн сургалтын автомашин, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, “Монгол малчин” хөтөлбөрөөс нийт 11,450.0 мянган төгрөгийн жолооны дадлагын автомашин, зөөврийн компьютер, Deluxe авто центрээс 2,285.0 мянган төгрөгийн хөшиг, ширээ, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 5,271.4 мянган төгрөгийн 3 үйлдэлт принтерийг тус тус үнэ төлбөргүй хүлээн авч, нийт 136,154.2 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Бараа материалын дансанд мал амьтад 2021 оны эхний үлдэгдэл 154 толгой мал тоологдож, 89 толгой малыг нас дэвшилтээр 9,970.0 мянган төгрөгийн, 35 толгой шинэ төлийг

1,400.0 мянган төгрөгөөр үнэ төлбөргүй орлогоор бүртгэж тайлагнасан байна. Тайлант онд мал эмнэлгийн актаар 5 толгой 350.0 мянган төгрөгийн малыг акталж устгасан.

***Авлага, өглөгийн талаар***:

2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаар авлагын үлдэгдэл 679.6 мянган төгрөг, өглөгийн үлдэгдэлгүй тайлагнагдсан. Харилцагч, бэлтгэн нийлүүлэгч хувь хүн, байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдэн баталгаажуулсан.

***Санхүүгийн байдлын тайлангийн талаар:***

2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар төрийн сангийн болон нэмэлт санхүүжилтийн дансанд 0.00 төгрөгийн үлдэгдэлтэй, арилжааны банкны харилцах дансгүй байна. Бараа материал 52,819.8 мянган төгрөг, үндсэн хөрөнгө 1,241,459.3 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | | - |
| Авлага | 679.60 | 679.60 | - |
| Урьдчилгаа | | | - |
| Бараа материал | 101,231.98 | 52,819.80 | (48,412.18) |
| Үндсэн хөрөнгө | 1,202,084.97 | 1,241,459.31 | 39,374.34 |
| **Нийт хөрөнгө** | **1,303,996.55** | **1,294,958.71** | **(9,037.84)** |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,303,996.55 | 1,294,958.71 | (9,037.84) |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1,303,996.55** | **1,294,958.71** | (9,037.84) |

Бараа материалын дансны үлдэгдэл 52,819.8 мянган төгрөг болж, оны эхний үлдэгдлээс 48,412.2 мянган төгрөгөөр буурсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,241,459.3 мянган төгрөг болж 39,374.3 мянган төгрөгөөр өссөн нь Жигд хүч ХХК, НҮБ-ын ХХААБ, “Монгол малчин” хөтөлбөр, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас үнэ төлбөргүй 136,154.2 мянган төгрөгийн хөрөнгө хүлээн авч, хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалж байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,294,958.7 мянган төгрөг болж 9,037.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

**3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.6.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллага нь 2021 оны төсвийн төсөлд төсвөөс санхүүжих эх үүсвэрийг 1,186,522.5 мянган төгрөгөөр төлөвлөн, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн  хүргүүлсэн төсвийн төслөөс бараа ажил үйлчилгээний зардалд 1,063,315.8 мянган төгрөг, татаас ба урсгал шилжүүлгийн зардалд 91,729.5 мянган төгрөгийг санхүүжүүлэхээр баталсан байна.

**3.6.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн гүйцэтгэлийн тайлангаар улсын төсвөөс 1,146,545.3 мянган төгрөгийн санхүүжилт, 3,170.0 мянган төгрөгийн үндсэн болон туслах үйл ажиллагааны орлого, нийт

1,149,715.3 мянган төгрөгийн эх үүсвэрийг төвлөрүүлж, урсгал үйл ажиллагаандаа 1,120,796.7 мянган төгрөгийг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулж, зарцуулаагүй үлдэгдэл 34,248.6 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,120,796.7 мянган төгрөг буюу 97.0 хувьтай хэрэгжсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд орлого төвлөрөөгүй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

## 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Үндсэн хөрөнгө дансанд Жигд хүч ХХК-аас нийгмийн хариуцлагын хүрээнд 5,000.0 мянган төгрөгийн гагнуурын ангийн тоног төхөөрөмж, НҮБ-ын ХХААБ-аас нийт 112,147.8 мянган төгрөгийн сургалтын автомашин, тоног төхөөрөмж, тавилга эд хогшил, “Монгол малчин” хөтөлбөрөөс нийт 11,450.0 мянган төгрөгийн жолооны дадлагын автомашин, зөөврийн компьютер, Deluxe авто центрээс 2,285.0 мянган төгрөгийн хөшиг, ширээ, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас 5,271.4 мянган төгрөгийн 3 үйлдэлт принтерийг тус тус үнэ төлбөргүй хүлээн авч, нийт 136,154.2 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн байна.

Бараа материалын дансанд мал амьтад 2021 оны эхний үлдэгдэл 154 толгой мал тоологдож, 89 толгой малыг нас дэвшилтээр 9,970.0 мянган төгрөгийн, 35 толгой шинэ төлийг 1,400.0 мянган төгрөгөөр үнэ төлбөргүй орлогоор бүртгэж тайлагнасан байна. Тайлант онд мал эмнэлгийн актаар 5 толгой 350.0 мянган төгрөгийн эм төлийг актлаж устгасан.

## 3.8 Аудитын гол асуудал

Үндсэн хөрөнгө дансанд Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, НҮБ-ын ХХААБ, “Монгол малчин” хөтөлбөр, Жигд хүч ХХК-аас нийгмийн хариуцлагын хүрээнд үнэ төлбөргүй хүлээн авсан 136,154.2 мянган төгрөгийн хөрөнгө нэмэгдсэн.

## 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс 125 мэдээллийг хугацаандаа, 14 мэдээллийг хугацаа хоцроож, хугацаа болоогүй 2 мэдээлэл, 8 мэдээллийг огт мэдээлээгүй төлөвтэй байна.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгөгдсөн 2,211.3 мянган төгрөгийн төлбөрийн акт, 5,256.7 мянган төгрөгийн албан шаардлага, 679.6 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгөгдсөнийг тайлант хугацаанд бүрэн хэрэгжүүлж, зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дах Төрийн аудитын газар болон “Ихмонгол Хөлөг Аудит” ХХК-д хүргүүлсэн байна. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн алдаа зөрчил давтан гараагүй байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Эрдэнэ суман дах Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвд санхүүгийн тайланд аудит хийх явцад дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал гараагүй ба аудитаар бичигдсэн бараа материалын бүртгэлтэй холбоотой зөвлөмжийн хэрэгжилтийг шалгах нь зүйтэй гэж үзлээ.

## 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 16,574.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 14,429.5 мянган төгрөгийн алдаа зөрчлийг залруулж, 106.1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 2,038.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өгөв.

### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Биет бус хөрөнгийн дансанд бүртгэлтэй нийт 138,972.0 мянган төгрөгийн үнэ бүхий газар өмнөх оны хуримтлагдсан элэгдэл 5,285.7 мянган төгрөг, тайлант жилд 5,285.7 мянган төгрөг, нийт 10,571.4 мянган төгрөгийн элэгдэл илүү тооцож тайлагнасан нь: НББ-ийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “Холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэсэнтэй нийцэхгүй байна.

   *<u>Шийдвэрлэсэн нь:</u>* НББ-ийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

2. Тайлант хугацаанд нийт 3,858.0 төгрөгийн үнэ бүхий ЕБС-ийн сургалтын үйл ажиллагааг бүрэн автоматжуулсан "EMIND" программыг худалдан авсан бөгөөд дээрх программ хангамжийг биет бус хөрөнгөөр бүртгэж тайлагнаагүй нь: НББ-ийн тухай хууулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д "Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ:14.4.5-д “бүх орлого" гэсэнтэй нийцэхгүй байна.

   *<u>Шийдвэрлэсэн нь:</u>* НББ-ийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

### 4.2 Төлбөрийн акт

Аудитаар 106.1 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоов. Үүнд:

1. Байгууллагын удирдлагын тушаалаар баталсан хувь хэмжээг нэмэгдүүлэн 4 албан хаагчид нийт 106.1 мянган төгрөгийн Үр дүнгийн урамшуулалт цалин илүү олгосон нь: Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж , зарцуулах” гэсэнтэй нийцэхгүй байна.

   *<u>Шийдвэрлэсэн нь:</u>* Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журмын 12.11.2 дах заалт, журмын хавсралт №2-д заасныг үндэслэн илүү олгосон нэмэгдэл цалинг холбогдох этгээдээр төлүүлэх төлбөрийн акт тогтоов.

### 4.3 Албан шаардлага

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал гараагүй болно.

### 4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Зардлын данстай холбоотой асуудал***

*1.1. <u>Илрүүлэлт:</u>*

Тайлант хугацаанд үнэ төлбөргүй хүлээн авсан 2 автомашины тээврийн хэрэгслийн иж бүрэн даатгалд хамруулж нийт 1,760.0 мянган төгрөгийн даатгалын төлбөр төлсөн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д “төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.5 “Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэнтэй тус тус нийцэхгүй, “Иж бүрэн байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*1.2. <u>Өгсөн зөвлөмж</u>:*

Батлагдсан төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зориулалтын дагуу зарцуулж байх

### ***2. Бараа материалын данстай холбоотой асуудал***

*2.1. <u>Илрүүлэлт:</u>*

Тайлант хугацаанд 1 нэр төрлийн 278.9 мянган төгрөгийн үнэ бүхий хөрөнгийн шинжтэй тоног төхөөрөмжийг бараа материалын дансанд бүртгэж, бараа материалын орлогоор хүлээн авсан даруй зарцуулсан байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2018 оны 06 дугаар сарын 19-ны өдрийн 273 тоот тогтоол, УСНББОУС 12 болон УСНББОУС 17-той тус тус нийцэхгүй, “Оршин байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*2.2. <u>Өгсөн зөвлөмж</u>:*

Хөрөнгө материалыг зөв ангилан бүртгэж, хөрөнгийн шамшигдал үүсгэхгүй байх

### ***3. Шилэн данстай холбоотой асуудал***

*3.1. <u>Илрүүлэлт:</u>*

Тайлант хугацаанд Шилэн дансанд мэдээлбэл зохих 149 мэдээллээс 125 мэдээллийг хугацаандаа, 14 мэдээллийг хугацаа хоцроож, хугацаа болоогүй 2 мэдээлэл, 8 мэдээллийг огт мэдээлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", мөн хуулийн 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэнтэй тус тус нийцэхгүй, “Нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

*3.2. <u>Өгсөн зөвлөмж</u>:*

Шилэн дансанд байршуулах мэдээллийг хуулийн хугацаанд үнэ зөв бүрэн мэдээллэж байх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дах Төрийн аудитын газар болон “Дундманхайдай Аудит” ХХК-д 2022 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | дүн | Тоо | дүн | Тоо | дүн | Тоо | дүн | Тоо | дүн |
| 1 | Төв аймгийн Эрдэнэ суман дах Мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төв | 6 | 16,574.5 | 2 | 14,429.5 | 1 | 106.1 | - | - | 3 | 2,038.9 |

Монгол улс, Төв аймаг, Зуунмод сум
6 дугаар баг, Төрийн захиргааны 2 байр
Утас:  +976  70272582,  +976  70273204
И –мэйл: tuv@audit.gov.mn, Вебсайт:
www.audit.mn